



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/313

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ойжуулалт нөхөн сэргээлт ажил хийх (37 га, Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон, Хутаг-Өндөр) 2 дугаар багц Орхон сумын "Оргилын ар" 10 га талбай Сумын төвөөс 40-45 км, Хутаг-Өндөр сумын "Тахилт" 5 га талбай сумын төвөөс 20-25 км, Бугат сум "Гэээг" 5 га талбай сумын төвөөс 10-15 км газарт шилмүүст модны суулгацаар ойжуулалтын ажлыг нийт 20 га талбайд хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Хөвөнтөн-ой" ХХК-тай 53,304,000 (Тавин гурван сая гурван зуун дөрвөн мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Хөвөнтөн-ой" ХХК-ийн захирал (Ч.Оюун)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010401

05 дугаар сарын 07 ний өдрийн А/313 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Бумцэнд
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	А.Гантөмөр